

Хэнтий аймгийн Баян-Адрага сум


1. Нутаг дэвсгэрийн хэмжээ, газар зүйн байршил, онцлогийн талаар

Биндэръяа хан уулын хошуунд 1500 өрхтэй 10 сум буй болсны нэг нь 1923 онд байгуулагдсан Шуусын голын хөвөөний Баян-Өлзийт сум бөгөөд тэр нь одоогийн Баян-Адрага сум байжээ.

Баян-Адрага сум нь баруунаараа Биндэр, зүүн хойгуураа Дадал, зүүнээрээ Норовлин, урдуураа Батноров сумтай хиллэн 3021 ам км талбай бүхий нутаг эзлэн оршино. Сумын төвийн өмнө байрлах Дуурлиг овоо нь Онон мөрний хөвөөнд далайн түвшнөөс дээш 1000 орчим митер өндөрт х.ө 480 33i , з.у 1110 05i -ын солбицолд Өндөрхаанаас хойш 154 км, УБ –с 440 км зайтай оршино.

Сум нь 2.4 мянган хүн амтай. Дуурлиг нарсанд орших “хүннүгийн булш”-ийг улсын хамгаалалтанд авсан.Сумын тахилгат уул нь Адрагын овоо, Баян-Өлзийт, Авшиг овоо, Арангат овоо гэсэн гол тахилгат овоонууд байдаг. Сумын нутаг дэвсгэр нь Хэнтийн нурууны зүүн зах, Эрээний нурууны баруун урд захын намхан уул толгодод байрлана. Сумын нутгийн зүүн хэсэгт орших 1437м өндөр Хөх чулуут уул нь сумын хамгийн өндөр уул юм. Сумын хамгийн нам цэг нь Онон гол сумын нутгаас гарч буй хэсэгт далайн түвшнээс дээш 930 м орчим юм. Өнгөт төмөрлөг, жонш зэрэг баялагтай. Сумын нутгаар алдарт Онон гол 80 орчим км урсана.

Ононгийн цутгал Арангат, Шуус, Урт, Баруун булаг, Хүйтэн, Сайхан зэрэг гол горхи урсана. Сайн цагаан, Холбоо, Шийр-Улаан, Баян зэрэг нуруудтай. Гидрокарбонат – кальци- магнийн найрлагатай Арангатын рашаан бий.Тайгын ширэгт, Хар шороон, хар хүрэн, хүрэн хөрстэй, шинэст, нарс, хус, улиасан ойтой, мойл, улаалзгана, өрөл зэрэг жимсгэнэ элбэг. Уулын хээрийн бэлчээр хадлангийн ургамалтай. Нэн ховор амьтан Цэн тогоруу, ховор амьтадаас тоодог, буга, бусад амьтадаас дагуур зараа, гахай, шилүүс, чоно, үнэг, хярс, тарвага болон усны, нүүдлийн шувуудтай. Гол мөрдөөр нь тул, зэвэг, цагаан хадар, амрын хадран, амрын цурхай, амрын сугас, улаан живэрт, морин загас, мөнгөлөг хэлтэг, булуу цагаан, цулбуурт гутаар зэрэг загас бий. Нутгийн хойд хэсэг Онон Балжийн байгалийн цогцолборт газарт багтана. Хувийн хэвшлийн 16 байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Сумын эдийн засгийн голлох салбар нь газар тариалан, худалдаа үйлчилгээ юм. Газар тариалангийн “Идэр-Онон” ХХК, “Мөнхийн Дуурлиг” ХХК зэрэг ААНэгж тариалалт хийдэг ба нийт эргэлтийн талбай **3200** га байдаг.



Баян-Адрага сумын газрын зураг

Адрагын овоо

Адрагын овоо нь сумын төвөөс зүүн тийш 42 км-т оршдог. Монгол бичгийн тоо тамгатай шарга азарга уулын эзэн байдаг гэж нутгийн өвөг дээдэс ярьдаг. Тийм учираас энэ овоог шарга адуугаар тахидаг байжээ. 1930-д оны үед Дамбаагийн ах нутгийн иргэн Дамдин гэгч малд явж байгаад

Адрага овооны өврөөр шарга азарга унасан ноён хүн яьж байхыг харсан гэдэг. Тэр нь Адрага овооны эзэн нь байсан учир энэхүү төгс буянт хүнтэй таарсан дээрхи хүн баян чинээлэг явах бэлэг дэмбэрэл нь бий болсон гэж нутгийн ард иргэд ярих болсон гэнэ. Энэхүү уул овоог тухайн газарт төрж өссөн нутгийн иргэд, нутгийн лам хувилгаан Минжүүрийн хүү Лүндэгдамчаа, нутгийн лам Базардарь нараар “Баян Намсрай” ,”Дашзэвэг найман гэгээн”, “Хийморийн сан”, “Сахиус” ном судар айлдуулж, тахин шүтэж өнөөг хүрчээ. Уул овоонд гарахдаа уг овоонд эрт дээр үеэс өргөл барьц болгон тахилганд барьж жанссан “Алтан ганжир”-ыг иргэдийн сүсэг бишрэлийн дагуу залж хэвшсэн байна.



Алтан ганжирт Адрага овооны зураг

Баян-Өлзийт хайрхан

Уг овоо нь сумын төвөөс зүүн урагш 16 км-т оршдог эрт дээр үеэс нутгийн ард иргэд өөрсдийн сүсэг бишрэлийн дагуу тахин шүтэж, морь уралдах, бөх барилдах, сур харвах зэрэг бэсрэг наадам зохион байгуулж ирсэн түүхтэй бөгөөд байгалийн үзэсгэлэн төгөлдөр, онгон дагшин уул овоо юм. Уг овоо нь хэрэв өдөр судар, ёс горим, ном судраа зөв уншиж тахиж чадаж гэмээ нь овооны энгэрээс лусын амьтан могой гарч ирж нутгийн иргэдийг гайхшруулдаг байжээ. Тэрхүү амьтан гарч ирсэн тэр жил дэлхий дэлэгнэж хүн малын зоо тэнийсэн, төр түвшин, түмэн олон амгалан байх нигууртай хэмээн нутгийн өвгөд хуучилдаг байв.



Баян-Өлзийт хайрханы зураг

Арангат овоо


Уг овоо нь сумын төвөөс баруун тийш 24 км-т оршдог. Эрт дээр үед Эрдэнэцогтын овоо гэдэг нэртэй байжээ. 1940-өөд оноос эхлэн тахиж ирсэн бөгөөд 1950-аад оны эцэс хүртэл Ц.Дамби-Очир гэдэг хүн овооны дарга байсан байна.сүүлд Ц.Дамби-Очирын хүү Даш гэдэг хүнээр дарга болгосон. Харин 2003 оноос Г.Эрдэнэцогт дарга болсон, Г.Зулбадрах, Моломжамц зэрэг лам ном уншдаг байжээ.Энэхүү овоо нь тахилга үйлдэж, ном судар уншин, хэнгэрэг цан цохих үед овооны энгэрээс үнэг гарч ирж овоо тойрон явдаг бөгөөд энэ овоо нь үнэг эзэнтэй овоо хэмээн тахин шүтэж энэ орчмын ан амьтанг агнахыг цээрлэж иржээ.Энэ овоог тахихад “Баян Намсрай”, “Дашчирав”, “Цагаан өвгөөний сан “, “Хийморийн сан” зэрэг ном уншдаг бөгөөд нутгийн иргэд сүсэг бишрэлийн дагуу идэвхитэй оролцдог байна.

Авшиг овоо

Уг овоо нь сумын төвөөс зүүн урагш 25 км-т оршдог бөгөөд нутгийн өвөг дээдэс, гадна дотны хүмүүс уг орон нутагт ажиллаж амьдарч байгаа настан буурлууд тахин шүтэж ирсэн өвөрмөц тахилгат уул овоо юм. Уг овоог тахихад гол төлөв гадны нутгаас тус суманд амьдарч байгаа иргэд, нутгийн өвөг дээдсийн хамт тахин шүтэж ирсэн бөгөөд “Хийморийн сан”, “Ламаадан”, “Баян Намсрай”, “ Сахиус” зэрэг ном уншиж тахин шүтэж иржээ.

1. Хүн амын тоо, яс үндэс, соёл уламжлал ёс заншлын талаар

БАЯН-АДРАГА СУМЫН ХҮН АМ 2012-2016 ОН




2. Сумын бренд бүтээгдэхүүн түүний онцлог

Тус суманд 2003 оноос Идэр-Онон ХХК, 2011 оноос Мөнхийндүүрлиг ХХК –ны хоёр гурилын үйлдвэр ажиллаж “ Сайхны буудай” ,” Ургац” нэртэй гурил үйлдвэрлэж сум болон бүсийн сумдын гурилын хэрэгцээг ханган ажиллаж байна.

3. Малын тоо ангилал, сүүлийн 5 жилээр


БАЯН-АДРАГА СУМЫН МАЛЫН ТОО 2012-2016 ОН



	2012	2013	2014	2015	2016
Нийт малын тоо	77302	86571	104771	115832	129753
Ямаа	26949	30468	36459	39195	44556
Хонь	36222	41229	51335	58148	65564
Үхэр	7930	8654	10159	11332	11815
Адуу	6109	6138	6752	7099	7758
Тэмээ	92	82	66	58	60

4. Амьтан ургамлын аймаг, төрөл зүйл ангиллын талаар

Баян-Адрага сумын гадарга нь өөр хоорондоо ялгаа бүхий ландшафттай бөгөөд нийт нутаг дэвсгэрийн 54.5 хувь буюу 164898.4 га талбайд дундаж өндөр ба нам бэсрэг уулын, 17.6 хувь буюу 53169.4 га-д тал хээрийн, 8.9 буюу хувь 26918.9 га-д бүс дундын голын хөндий нам хотосын нугын, 5.6 хувь буюу 16993.4 га-д нам бэсрэг уулс хоорондох нуга хөндийн ургамал тархсан байна.



Сумын ургамлын экологийн хэв шинжийн зураг

Сумын ургамалжилт, төрлөөр:

Сумын нутаг дэвсгэрийн 17.2 хувийг ой, нуурын талбай, үлдэх 82.8 хувийг бэлчээр эзэлж байна. Үүнээс нутгийн 33.9 хувь буюу 95223.3 га талбайд жижиг дэгнүүлт үетэн алаг өвст бэлчээр тархсан байна.

зүй Хүснэгт 1. Сумын бэлчээрийн ургамлын анги, төрөл зүйл

Анги		Бүлэг, төрөл	Ургамал	Талбайн хэмжээ /га/
Бүс дундын голын хөндий, нам хотосын нутын бэлчээр	Аллювийн нутын болон хэрэгжсэн нутын үелсэн сулавтар хөгжилтэй хорстэй татамын нута	Алаг өвст	Алаг өвс - улалжит	847.9
			Улалж - үетэн - алаг өвст	5953.1
		Улалжит	Улалж - үетэн - алаг өвст, улалж - үетэнт	1927.76
			Улалж - үетэн - алаг өвст, хялгана - жижиг дэгнүүлт, үетэнт	1387.08
		Дэгнүүлт үетэнт	Улалж - үетэн - алаг өвст, шарилжит	7637.11
			Үетэн - улалж - алаг өвст	3933.35
			Үетэн - улалж - алаг өвст, улалжит	4565.98
			Үетэн - улалж - алаг өвст, улалжит, хялгана - зүр өвс	666.48
			Үетэн - шахирлаг - алаг өвст	0.14
	Тэгшнвэр болон нугачаат хөндийн шавранцар хүрэн хорстэй хээр Дэгнүүлт үетэнт	Алаг өвст	Алаг-үетэнт	281.78
		Улалжит	Жижиг улалж - үетэнт, шарилжит	338.12
		Алаг өвст	Зүр өвс - алаг өвст	6682.28
		Дэгнүүлт үетэнт	Биелэг - үетэнт, биелэг - хиагт, шарилжит	624.26
			Ботуул - жижиг дэгнүүлт үетэн - алаг өвст	1870.15
			Ботуул - жижиг дэгнүүлт үетэн - алаг өвст, шарилж	953.49
			Хялгана - жижиг дэгнүүлт үетэнт, хялгана-алаг өвст, шарилжит	2095.68
			Хялгана - жижиг дэгнүүлт үетэнт, шарилжит	758.09
			Хялгана - жижиг дэгнүүлт, үетэнт, хялгана - алаг өвст	634.07
			Хялгана - зүр өвст	7035.81
			Хялгана - хиагт, алаг өвст, шарилжит	2173.14
			Хялгана - хиагт, дааган сүүлт, шарилжит	243.21
			Хялгана - хиагт, шарилжит	5370.33
			Хялганат, хялгана - алаг өвст	5294.02
			Хялганат, хялгана - алаг өвст, хиагт	835.18
			Хялганат, хялгана - алаг өвст, шарилжит	6681.48
			Хялганат, хялгана - алаг өвст, шарилжит, жижиг дэгнүүлт үетэнт	6953.09
			Хялганат, хялгана - алаг өвст, шарилжит, хиагт	2579.58
		Үндэслэг ишт үетэнт	Хиагт, хиагт - алаг өвст	384.18
			Хиагт, хиагт - алаг өвст, шарилжит	1381.44

Нам бэсрэг уулын хоорондох нута хөндий	Уулын хоорондох хөндийн гүндээ шэвдэгтэй хар шороон ба хар хүрэн хөрстэй уулын нута	Алаг өвст	Зүр өвс - алаг өвс - үетэнт		
			Зүр өвст - хялганат	507.23	
			Зүр өвст - хялганат, хялганат - зүр өвст	1068.7	
		Улалжит	Улалж - үетэнт	2051.88	
		Дэгнүүлт үетэнт	Улалж - үетэнт, шарилжит	687.29	
			Улаан толгой - улалж - алаг өвст	158.78	
Дундаж өндөр болон нам, бэсрэг уулын бэлчээр	Уулын сул хөгжилтэй хар хүрэн ба хар шороон хөрстэй нугархаг хээрийн сийрэг ургамалтай чулуурхаг бэлчээр	Дэгнүүлт үетэнт	Ботууль - алаг өвст, ботууль - зүр өвст		
			Ботууль - алаг өвст, ботууль - хялганат	5495.74	
			Ботууль - алаг өвст, зүр өвст - жижиг дэгнүүлт үетэнт	6909.72	
			Ботууль - алаг өвст, зүр өвст - хялганат	18057.97	
			Ботууль - алаг өвст, хялгана - зүр өвст	4014.28	
			Жижиг дэгнүүлт үетэн - алаг өвст, зүр өвс - хялганат	5368.56	
	Уулын сул хөгжилтэй хүрэн, цайвар хүрэн хөрстэй сийрэг ургамалтай	Дэгнүүлт үетэнт	Жижиг дэгнүүлт үетэнт - алаг өвст - агьт		920.75
	Уулын хар хүрэн ба нугын улирлын шэвдэгт хар шороон хөрстэй нугархаг хээр	Дэгнүүлт үетэнт	Ботууль - зүр өвс, алаг өвст		3442.07
			Алаг өвст	Зүр өвс - хялганат, ботууль - зүр өвст	7186.61
		Зүр өвст, зөр өвс - алаг өвст		1316.17	
		Дэгнүүлт үетэнт	Хялгана - зүр өвст	7.82	
			Хялгана - зүр өвст, ботууль - зүр өвст	3381.08	
		Уулын хүрэн заримдаа хар хүрэн хөрстэй хуурай хээрийн бэлчээр	Дэгнүүлт үетэнт	Ботууль - алаг өвст	2395.78
	Ботууль - алаг өвст, хялгана - зүр өвст			11341.47	
	Ботууль - алаг өвст, хялгана - үетэнт			10361.87	
	Ботууль - алаг өвст, хялганат, хялгана - алаг өвст			5499.07	
	Ботууль - хялганат			960.24	
	Ботууль - хялганат, ботууль алаг өвст			488.32	
	Ботууль - хялганат, хялганат, хялгана - алаг өвст			9964.19	
	Хялгана - зүр өвст			9562.56	
	Хялгана - зүр өвст, ботууль алаг өвст			4744.04	
	Хялгана - зүр өвст, жижиг дэгнүүлт үетэнт - алаг өвст			9509.28	
	Хялгана - зүр өвст, зүр өвс - алаг өвст			3745.73	
	Хялгана - зүр өвст, зүр өвс - жижиг дэгнүүлт үетэнт			3393.14	

Сумын ургамалжилтын төлөв байдал:

Сумын нийт нутаг дэвсгэрийн 29.8 хувийг чулуутай бэлчээр, 25.4 хувийг цэвэр бэлчээр, 8.3 хувийг довонтой бэлчээр, 23.1 хувийг сөөгтэй бэлчээр тус тус эзлэн тархсан байна.

№	Хэв шинж	Талбайн хэмжээ, га	Эзлэх хувь
1	Нуур	367.04	0.12
2	Ой	11773.51	3.89
3	Цэвэр бэлчээр	76882.53	25.41
4	Чулуутай бэлчээр	90144.45	28.79
5	Сөөгтэй бэлчээр	69872.31	23.09
6	Довонтой бэлчээр	25080.89	8.29
	Нийт	338875.1	100.00



Сумын бэлчээрийн ургамалжилтын зураг

1. Ойн нөөц, төлөв байдал

Сумын нутаг дэвсгэрийн 9.56 хувийг ойн сан бүхий газар эзлэх бөгөөд үүнээс ойгоор бүрхэгдсэн талбай 18868.22 га буюу нийт ойн сан бүхий газрын 55.29 хувийг, ойгоор бүрхэгдээгүй талбай 14056.636 га буюу 45.71 хувийг эзэлж байна.

Хүснэгт 3. Сумын ойн сан бүхий газар, талбайгаар

№	Ойн сан бүхий газрын төлөв байдал		Талбай, га	Нийт ОБСГ-т эзлэх хувь
1	Ойгоор бүрхэгдсэн		18868.22	55.29%
	Үүнээс	Байгалийн ой	18677.88	
		Бут сөөг	190.34	
2	Ойгоор бүрхэгдээгүй		14056.636	44.71%
	Үүнээс	шатанги	2406.636	
		Тармаг ой	10381.2	
		Мод бэлтгэсэн талбай	21.28	
		Цагаан энгэр	281.440	
		Ойжих талбай	964.446	
Сумын нийт ойн сан бүхий газар			32924.856	100%

Адрага баг хамгийн их буюу 19487.97 га талбай бүхий ойн нөөцтэй, хамгийн бага нь Сайхан баг 1508.53 га талбайд ой тархсан байна. Нийт ойн сан бүхий газрын 60 гаруй


2. Ойн сан бүхий газрын ашиглалт



Сумын хэмжээгээр 12 нөхөрлөл, 1 компани ойн сан бүхий газрыг гэрээгээр эзэмшиж байгаа бөгөөд нийт ойн сан бүхий гакрын 55.2 хувь буюу 20768 га талбайг нөхөрлөлд олгосон байна.

Хүснэгт 4. Сумын ойн сан бүхий газрын ашиглалт

№	Нөхөрлөлийн нэр	Байгуулагдсан он	Талбай га	Үйл ажиллагааны чиглэл
	Алдар-Анд	2008.12.01	6101	Ойн
	Хүүш	2010.05.15	5970	Ойн
	Цагаан чулуут	2010.05.15	4395	Ойн
	Өлзийт хайрхан	2010.05.15	1170	Ойн
	Шувуут ногоон	2012.05.15	1710	Байгаль хамгаалах
	Шинэст онон	2012.03.23	969	Байгаль хамгаалах
	Онон	2010.05.15	44	Байгаль хамгаалах
	Байгалийн өгөөж	2010.05.15	1707	Байгаль хамгаалах
	Баянхангай	2012.03.23	2313	Байгаль хамгаалах



Сумын ойн сан бүхий газрын ашиглалтын зураг

3. Уул уурхайн ашиглалт

Сумын хэмжээнд 2013 оны байдлаар тус сумын нутагт ашиглалтын 1, хайгуулын 8 тусгай зөвшөөрөл бүртгэлтэй байдаг.

Хүснэгт 5. Сумын уурхайн зориулалттай газрын ашиглалт

№	Үйл ажиллагааны төрөл	Эзэмшигч	Байршил	Лицензийн төрөл
1	Жонш олборлох	Талст Орчлон ХХК	Сумын төвөөс зүүн тийш 8 км	2014 А 12960
	Хайгуулын өнгөт металл	Батшандас ХХК	Сумын төвөөс зүүн тийш 8 км	А14236
	Хайгуулын алт	Сауд гоби гоулд ХХК	Сумын төвөөс зүүн тийш 8 км	А13867
	Хайгуул	Харанга эрдэнэс ХХК	Сумын төвөөс зүүн тийш 8 км	А13867

Бусад үйл ажиллагаа: Сумын төвөөс урагш 35 км зайд 1-р багийн нутаг “Хөлийн холбоо”-д 2011 оноос 5 нөхөрлөл гар аргаар жонш олборлох үйл ажиллагаа явуулж байгаа. 2012 оны 8-р сард сумын ИТХ-ийн тэргүүлэгчдийн 29-р тогтоолоор 25.2 га талбайг орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан. 1980-аад оны дундуур тус газарт Бэрхийн уурхай ашиглалт явуулж байжээ.

4. Амьтны төрөл

Баян-Адрага сумын нутгийн ой тайгад хүдэр, халиун буга, бор гөрөөс, зэрлэг гахай, нохой зээх, шилүүс гэх мэт амьтад байх ба тал хээрийн амьтдаас бор туулай, монгол тарвага, шивэр алаг даага, хярс, үнэг, мануул, дагуур зараа, дагуур зурам, нохой элбэнх зэрэг 6 багт хамрагдах 54 зүйл хөхтөн амьтад байдгийг тогтоожээ. Сүүлийн жилүүдэд эдгээр амьтдын тоо толгой, тархац нутаг нь эрс багасч байгаа болно. Энд шувуудаас ховор болсон цэн тогоруу, хошуу галуу, усны цагаан сүүлт бүргэд, хонин тоодог, хар өрөв тас, хан бүргэд, зээрд шонхор зэрэг шувууд өндөглөн зусдаг ба цагаан, хар тогоруу, байгалийн нугас зэрэг шувууд нүүдлийн үедээ дайрч өнгөрдөг байна. Онон Балжийн сав газар 12 овгийн 28 зүйл загас тархсан байна.

5. Түүхийн дурсгалт газруудын тухай мэдээлэл

1. “Монгол их хатдын өргөө” цогцолбор

Сумын төвөөс 1 километрт Дуурлигийн дэнж дээр Онон голын бэлчирт “Монгол их хатдын өргөө” цогцолбор 2011 оны 06 дугаар сарын 17 –ний билэгт сайн өдөр үүдээ нээж нээлтийн ёслолд хүндэтгэл үзүүлэхээр монголын өнцөг булан бүрээс зочид төлөөлөгчид нэрт эмэгтэйчүүд хүрэлцэн ирж УИХ –ын дэд дарга асан Д. Лүндээжанцан, УИХ –ын гишүүд, ОХУ –ын БНБуриад улсын Нийгмийн хамгааллын сайд хатагтай Хамаганова, Наталья Николаевна, Бүх Оросын буддын шашны тэргүүн хамба Дамба-Аюуш нарын хүндэт зочид оролцон нутгийн 108 ээжүүд тэнгэр бурхандаа сүүн цацал өргөж домогт хатдын өлгий нутгаан аргадаж, монголын цэц мэргэн харваач эмэгтэйчүүдийн бэлгэдлийн үзүүлбэр, урлаг соёлын алдартай эмэгтэйчүүдийн урлагийн тоглолтоор өнгө нэмж их түүхийн бахархал болгон Их өргөө үүдээ нээсэн юм.

Хатан ухааны дээд мандах төрийн малгай гэгддэг богтог малгайгаар төв барилгыг бүтээж тойрсон есөн цагаан гэр, дөрвөн суваргаар мануулсан энэхүү өргөө нь наймдугаар Богд Жавзундамба хутагтын 2 хатан Цэндийн Дондогдулам, Наваанлуvsангийн Гэнэнпил нарын төрсөн Хөвчийн жонон вангийн хошууны гол цөм нутагт Монголчуудын эв нэгдлийг илэрхийлэх, монгол хатдын түүхэнд байгуулсан алдар гавьяаг алдаршуулах, дурсан санах, эрх чөлөө сэргэн мандлын төлөө хүчин зүтгэж явсан монгол их хатдыг хойч үедээ

сурталчлан таниулахад зориулагдан нутгийн иргэд эмэгтэйчүүдийн санаачлагаар УИХ –ын гишүүн Д. Арвины дэмжлэг хичээл зүтгэлээр байгуулагдсан.

Өргөөнд монголын түүхэнд алдар гавьяагаа мөнхөлсөн Алунгоо, Өүлэн эх, Бөртэ, Сорхугтани бэхи, Дөргөнө, Мандухай, Ану, Ханджамц, Энэ нутгаас төрсөн Дондогдулам, Гэнэпил нарыг монголын хатан судлаач түүхч эрдэмтдийн судалгааг үндэслэн тодруулж дүрийг нь мөнхлөн байрлуулсан.



Монгол хатдын өргөө цогцолбор

2. Дуурлиг Нарсны " Хүннү булш"

Сумын төвөөс баруун урагш 2 км орчим зайд оршдог. 1992 онд Түүх архилеогийн судлаачид, эрдэмтэд судалгаа хийж улсын хамгаалалтад авсан.

Баян-Адарга сумын төвийн өмнөх дугуйран ургасан нарсан ой дотор Хүннүгийн язгууртны 200 гаруй булш тархан байрлах бөгөөд эдгээр булшнууд уг газрын нэрээр алдаршжээ. Дуурлиг нарсны дурсгалт газар нь манай орны нутгаас илэрч тэмдэглэгдсэн Хүннүгийн язгууртны булш бүхий 6 том оршуулгын газрын нэг төдийгүй хамгийн зүүн захад байрлах дурсгал юм. Уг булшнуудыг Хүннүгийн зүүн жигүүрийг захирч байсан язгууртан дээдсийн оршуулга хэмээн таамагладаг.

Дурсгалт газрыг анх 1974 онд Хөдөөгийн Пэрлээ илрүүлсэн ба 1990 онд Монгол-Японы хамтарсан “Гурван гол” төслийн хүрээнд булшийг тоолж бүртгэн, бүдүүвч дэвсгэр зургийг үйлдсэн байна. Анхны археологийн малтлага судалгааны ажлыг Монголын Үндэсний музей, ШУА-ийн Археологийн хүрээлэн, Солонгосын Үндэсний музей хамтран хэрэгжүүлж буй “Мон-Сол” эрдэм шинжилгээний төслийн хүрээнд доктор Г.Эрэгзэнгийн удирдсан хээрийн шинжилгээний анги хийсэн бөгөөд тус шинжилгээний ангийхан 2006-2010 оны хооронд Хүннүгийн язгууртны оршуулгын дурсгал болох үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн гадаад байгууламжтай 3 булш, дугуй хэлбэрийн гадаад чулуун байгууламжтай 11 жижиг булшийг малтан судалсан байна.

Дээрх булшны малтлагын үр дүнд Хүннүгийн язгууртны булшны бүтэц зохион байгуулалтын талаар багагүй шинэ мэдээлэл цуглуулснаас гадна авсны алтан чимэг, хүрэл дэнгийн цөгц, хүрэл гүц, хүрэл толь, шувууны дүрстэй чулуун зүүлт, хаш эдлэл, хүрэл болон төмөр тогоо, төмөр шанага, шүүлтүүр, улзарсан хөөмөл хээтэй бүсний алтан чимэг, гоёмсог хийцтэй шавар ваар зэрэг ховор сонин олдвор эд өлгийн зүйлсийг илрүүлэн олжээ. Эдгээрээс төмөр тогоо, төмөр шүүлтүүр гэх мэт олдворууд нь өмнө нь Хүннүгийн дурсгалаас олдож байгаагүй шинэ олдворууд юм. Мөн шавар ваарны ёроолд дарсан тамга, хүрэл цөгцөн дотор хадгалагдсан өөхөн тос зэрэг хүннүчүүдийн оюуны болон эдийн соёлыг илтгэх шинэ содон эх хэрэглэгдэхүүн ч багагүй цугларсан байна.

Мон-Сол төслийн судлаачид 2009 онд малтлагаар илэрсэн олдворуудыг сэргээн завсарлаж Монголын Үндэсний музей, Солонгосын Үндэсний музейд үзэсгэлэн зохион байгуулж олон нийтэд сурталчилсан ба олон улсын эрдэм шинжилгээний хурал хийж

дурсгалт газрын малтлага судалгааны талаар дотоод гадаадын эрдэмтэн судлаачдад танилцуулсан нь Дуурлиг нарсны дурсгалт газрыг Монголд төдийгүй дэлхийд таниулан сурталчилахад чухал ач холбогдолтой үйл ажиллагаа болжээ.

Цаашид төслийн хүрээнд Дуурлиг нарсны дурсгалт газарт байнгын үзэсгэлэн(дурсгалт газрыг танилцуулах музей), судалгааны төв байгуулахаар төлөвлөж байна. Байнгын үзэсгэлэнгийн танхимтай болох нь дурсгалт газрыг үзэхээр ирэх жуулчин, энгийн иргэдэд төдийгүй гадаад, дотоодын судлаач, оюутан зэрэг бүхий л хүмүүст дурсгалт газрын талаар харьцангуй дэлгэрэнгүй бөгөөд тодорхой мэдээлэл өгөх чухал ач холбогдолтой билээ. Дээрх ажлууд бүрэн хэрэгжвэл Дуурлиг нарсны дурсгалт газар нь Хэнтий аймаг төдийгүй манай улсын Зүүн бүс нутгийн томоохон түүх-соёлын цогцолборын нэг болон хөгжих боломжтой юм.

Мон-Сол төслийн 2010 оны хээрийн шинжилгээний анги 6-р сарын 12-ноос 8-р сарын 8-ны өдөр хүртлэх хугацаанд дээр өгүүлсэн том булш(1-р булш хэмээн тэмдэглэсэн)-ны малтлага судалгааны ажлыг эхлүүлж, өнгөн хөрснөөс доош 10 м гүнд хүртэл малтан бүтэц зохион байгуулалтын талаар тодорхой мэдээлэл цуглуулсан юм. Мөн өмнөх жилүүдэд малтлага судалгаа хийж амжаагүй уг том булшны өмнө болон баруун хажууд байрлах 5 дагуул булшийг малтан судлав.

Төслийн 2010 оны хээрийн шинжилгээний ангид Монголын талаас доктор Г.Эрэгзэн, докторант Н.Батболд, М. Баярсайхан, магистр Д.Базаргүр, П.Алдармөнх нарын судлаачид, Солонгосын талаас Хун Жин-Гөн, Рюү Жон-хан, Чан Өн-жон, Чэ Сон-э нарын Солонгосын Үндэсний музейн судлаачид болон Ённам-ын археологийн судалгааны хүрээлэнгийн Юн Мин-гөн, Дэхан археологийн судалгааны хүрээлэнгийн Мүн Жи-ён, Паг Хён-рёл нарын судлаач, Улаанбаатарын Их сургууль, Боловсролын Их сургууль, орон нутгийн 15 оюутан оролцон ажилласан.





Хүннү дуурлигийн булшнаас олдсон олдворын зураг

3. Хүслийн мод

Байгалийн өвөрмөц шинж төрхийг харуулсан онцгойрон ургаж өнгө төрх шинж чанараа олон жил хадгалж байгаа энэхүү модыг нутгийн ард иргэд эрт дээр үеэс тахин хүндэтгэж, өөрийн хүсэл зорилгоо шивнэн итгэл үнэмшлээрээ бишрэн шүтэж ирсэн билээ. Түүнээс үүдэн хөрш зэргэлдээ сум, аймгийн ард иргэд гадны зочид төлөөлөгчид, аялал жуулчлалаар явж буй хүмүүс ч мөргөл үйлдэж хүслээ шивнэдэг болсоор “Хүслийн мод” он удаан жил алдаршсан



Хүслийн мод буюу жанжин модны зураг

4. Хүйтний хөшөө

Сумын төвөөс баруун урагш 35 километр Хүйтний хөндийд байрлах Чингис хааны түүхэн дурсгалд зориулсан гэрэлт хөшөөг 2006 онд сумын ЗДТГ –ын санаачлагаар ажилтан албан хаагчдын дэмжлэгээр бүтээн босгож, нутгийн иргэн С. Эрдэнэцогт бичээсийг бичиж үлдээсэн болно. Энэхүү гэрэлт хөшөөнд “Чингис хааныг дарахаар Жамуха тан эвлэлдэн довтолж ирэх үед Чингис хаан Хүйтэнд тосон байлдаж буй үедээ хүзүүний судсандаа хүнд шарх авч ихэд зовсон бөлгөө” хэмээн бичиж хөшөөний оройд аян дайны замд авч явдаг хар сүлдийг сийлбэрлэсэн. “Монголын нууц товчоо” –ны 147, 148-р зүйлд дурдагдсан Хүйтний хөндий нь Монголын түүхэн газар зүйч О.Сүхбаатар докторын судлан тогтоосноор энэхүү газрыг сонгон Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойд зориулан гэрэлт хөшөө боссон түүхтэй. Хүйтний хөндийд Чингисийн гурван түүхэн үйл явдалтай холбоотой байдаг. Чингис хаан дайны талбарт хамгийн хүнд шархыг хүзүүндээ авсан, Өөрийн итгэлт жанжин 9 өрлөгийн нэгэн Бэсүлийн Зургаадай Зэвтэй анд нөхөрлөсөн, энэхүү түүхэн тулалдаанаар Гүр хаан Жамухыг дарж их хаан болох зорилготой байсан түүхтэй нутаг болно. Хүйтний хөндийн түүхэн тулалдаан нь Монголын Нууц товчоонд тэмдэглэгдсэнээр 1200 онд болсон үйл явдал юм.



Хүйтний хөшөөний зураг

5. Буурлын агуй

Сумын төвөөс хойш 42 км Адрага багийн нутагт Буурал хайрханы баруун урд бэлд оршдог. Энэхүү байгалийн өвөрмөц тогтоцтой “Агуй” нь Буурал хайрханы баруун урд энгэрт хавчуу аманд байдаг ба Агуйн үүд нь 3 метр өргөнтэй, 2 метрийн урттай дотор нь ороход 5*6-н харьцаатай байдаг. Мөн баруун зүүн талд нь салбарласан дээрхитэй адил хэмжээний нуувч бүхий агуй байдаг. Эхний нуувчнаас дээш өгссөн замаар явахад уг

агуйн орой нь цоорхой байдаг бөгөөд дотор талдаа халуун зун ороход мөстэй, хүн даарахаар сэрүүхэн байдаг байна. Энэ агуйн баруун доод талд 50 орчим метрийн зайд тэмдэгт тавьж хамгаалалтад авсан. Мөн 2014 онд сумын ИТХурлын тогтоолоор орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан.



Буурлын агуйн зураг

6. Хүн чулуу

Сумын төвөөс зүүн урагш 18 км-т Сайхан багийн нутаг Божрын овооны энгэр бэлд оршдог хүн чулуу нь хүрэл зэвсгийн үеийн хөшөө дурсгал болохыг эрдэмтэн судлаачид тогтоосон билээ.



Хүн чулууны зураг

7. Чингисийн хэрмэн зам

Энэ замыг Чингис хаан засуулсан гэх тэр үед хааны бэр эцэгтээ ил харгадах ёсгүй байжээ. Иймээс Чингис хаан бэрийн хамт алс холыг зорих болсонд ёсыг дагаж олон мянган хүний хүчээр асар их шороон хэрэм бариулж, нэг талаар нь Чингис хаан нөгөө талаар нь бэр нь явсан гэдэг.

Байршил: Сумын хуучин төвийн баруун талаас эхлэн Хуурайн давааг чиглэн Нарийн хөндийд хүрч, Сайханы араас баруун талаар хөндий даган Сайнцагаан нуурын хойгуур гарч, Норовлин сумын Улзын өндөр дэв, Дорнод аймгийн Баяндун сумын нутаг Хэрмийн худаг зэрэг газраар дамжин Цагаан-Овоо, Сэргэлэн, Гурванзагал сумдын нутгаар БНХАУ-ын нутаг хүртэл хэсэг хэсэг газар тасран үргэлжилсэн шороон хэрэм юм. Урт нь 500 – 600км байдаг.



Чингисийн хэрмэн замын зураг

8. Арангатын рашаан

Сумын төвөөс баруун урагш 24 километрт Жаргалант багийн нутаг Арангат хэмээх газар оршдог энэхүү рашаан нь хүний биеийн ходоод гэдэс, цөс зэрэг дотор эрхтэнд сайн нөлөөтэй болохыг нутгийн иргэд болон эмч судлаачид тогтоон эмчилгээний журмаар нутгийн иргэд байнга хэрэглэж байдаг билээ.

Дээр үеэс ахмад настнуудын зөвлөгөөг даган хоол ундандаа хэрэглэж энэхүү рашааны ид шидийг хүртэн нутгийн олон он удаан жил хүртэж ирсэн уламжлалтай.

9. Шуусын боом

Сумын төвөөс зүүн зүгт 38км Адрага багийн нутагт Онон Шуусын гол 2-ын уулзвар бөгөөд байгалийн өвөрмөц тогтоцтой үзэсгэлэнт газрын нэг юм.



Шуусын боом


6. Байгалийн баялаг, ашигт малтмалын орд газрын

Манай суманд бичил уул уулрхай эрхлэгч жоншны 5 нөхөрлөл байдаг. Үүнээс идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг “Эвийн хүч”, “Хайрхан баялаг”, “Баялаг”, “ББГ андууд” гэсэн нөхөрлөлүүд байдаг.

Хүснэгт Жоншны нөхөрлөлүүдийн судалгаа

Д/д	Нөхөрлөлийн нэр	Орд нэр	Гишүүдийн овог нэр	Хүйс	Регистрын дугаар	Оршин суугаа хаяг	Ам бүл	Солбицол	Байршил, газрын нэр	Төлбөй хэмжээ /га/
1	Баян-Адрага сум	Жонш						48°13'23.89" 111°09'02.32"	Сайхан баг "Хөлийн холбоо"	
2	"ББГ Андууд"	Жонш	Шатар Базаррагчаа ахлагч	эр	св:48051818	Дуурлиг баг	2	48°14'09.5" 111°08'31.9"	Сайхан баг "Хөлийн холбоо"	0.4
			Шарав Норовсамбуу	эр	св:62020318	Дуурлиг баг	4	48°14'05.4" 111°08'42.0"		
			Балданлхам Ганцэнд	эр	св:77070911	Адрага баг	1	48°14'08.3" 111°08'42.0"		
			Дашзвэг Ган-Эрдэнэ	эр	св:75011719	Адрага баг	5	48°14'08.67" 111°08'39.7"		
			Баясанжав Баясанжаргал	эр	св:85010407	Адрага баг	5			
3	"Баялаг"	Жонш	Дамбийням Батбаатар ахлагч	эр	ет:53040313	Сайхан баг	2		Сайхан баг "Хөлийн холбоо"	
			Баатардулам Золзаяа	эр	св:86011014	Хэ Бор-өндөр	3	48°14'09.1" 111°08'39.7"		
			А.Мөнхцалмэг	эм	нз:85041314	Хэ Бор-өндөр	4	48°14'07.9" 111°08'37.6"		
			Гантөмөр Батбаяр	эр	ок:80081313	Хэ Бор-өндөр	4	48°14'07.9" 111°08'36.7"		
			Баясанжав Болортуяа	эм				48°14'09.0" 111°08'38.7"		
			Цэрэндорж Батгэрэл	эр	св:66111813	Баян-Адрага	5			
			Авирмэд Өлзийсайхан	эм	св:72032407	Баян-Адрага	5			
4	"Эвийн хүч"	Жонш	Хоохой Батотгон	эр	св:66071571			48°13'21.0" 111°09'24.6"	Сайхан баг "Хөлийн холбоо"	0.32
			Сэрүүл Хадбаатар	эр	хд:77052013			48°13'15.9" 111°09'48.5"		
			Маам Бэйгалмаа	эм	зл:71041101			48°13'12.5" 111°09'50.4"		
			Түвшинбаяр Хишигням	эр	зб:90122017			48°13'17.8" 111°09'23.8"		
			Ганбат Солонго	эм	пб:89070200					
5	"Есөн-Эрдэнэ"	Жонш	Дашбямба Ням	эр	св:67042219	Сайхан баг	4	48°13'21.1" 111°10'03.4"	Сайхан баг "Хөлийн холбоо"	0.16
			Дугардаш Должин	эм	св:65032603	Сайхан баг	4	48°13'21.6" 111°10'03.3"		
			Нэргүй Болорчимэг	эм	св:82072667	Дуурлиг баг	4	48°13'20.6" 111°10'00.5"		
			Б.Шинэбаяр	эр	св:87092117	Дуурлиг баг	5	48°12'14.8" 111°10'00.8"		
			Цээнцэр Нямбадна	эр	св:59032412	Дуурлиг баг	4			
6	Хайрхан баялаг	Жонш	Аюуш Адъяажав	эр	йв:73020416	Сайхан баг	1	48°14'05.3" 111°08'37.9"	Сайхан баг "Хөлийн холбоо"	0.16
			Нэргүй Одсайхан	эр	св:68022211	Сайхан баг	3	48°14'06.4" 111°08'38.0"		
			Цэвээнсүрэн Түмэнжаргал	эр	св:84012400	Жаргалант баг	4	48°14'05.8" 111°08'31.8"		
			Миланков Төгөлдөр	эр	св:91010513	Дуурлиг баг	2	48°14'07.0" 111°08'36.0"		
			Мийленков Очир	эр	св:81092513	Жаргалант баг	4			





Жоншны олборлолт явуулж буй үйл явцын зураг

Өнөөдрийн байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа жижиг дунд үйлдвэрлэлийн талаар

Гурлын үйлдвэр, гэрийн модны үйлдвэр, гэрийн модон тавилганы өрхийн үйлдвэр, талхны цех , дурсгал, сүлжмэл хувцасны өрхийн үйлдвэрлэл , алт мөнгөний дархан,хэвлэлийн газар тогтмол үйл ажиллагаа явуулж байна.



Хэвлэлийн үйлчилгээ явуулж буй зураг

Иргэн Д.Гүрцог 4, 5, 6 ханатай гэрийг захиалгаар хийдэг бөгөөд үйлдвэрлэлийг 2011 оноос эхэлсэн. Жилд 5-6 гэр захиалгаар хийдэг мөн авдар хийж эрээлэх үйлчилгээг үзүүлдэг.



Гэрийн модны өрхийн үйлдвэрлэлийн зураг

Арангат горхи хоршоо цөцгий тос, төрөл бүрийн ааруул үйлдвэрлэж аймаг, улсын намрын үзэсгэлэн худалдаанд сүүлчийн 6 жил тасралтгүй амжилттай оролцож ирсэн



Арангат горхи хоршооны үйлдвэрлэсэн сүү сүүн бүтээгдэхүүний зураг

Гэрийн төрөл бүрийн модон тавилгыг захиалгаар иргэн Д.Батбилэг 2006 оноос эхлэн эрхэлж байна. Хил залгаа сумдын захиалгаар мөн тавилгыг үйлдвэрлэн нийлүүлж байна.



Иргэн Д.Батбилэгийн үйлдвэрлэж буй модон тавилгын зураг



Сумын иргэд бүлэг байгуулан эсгийгээр бэлэг дурсгалын зүйлс хийж борлуулалт хийж байна.



Сумын иргэн Р. Мөнхтөгс төрөл бүрийн мөнгөн аяга, хэрэглэл иргэдийн захиалгаар үйлдвэрлэж байна.

7. Цаашид хөгжүүлэх боломжтой үйлдвэрлэл үйлчилгээ, сумын хэтийн хөгжлийн төлөвийн талаархи мэдээлэл

Суманд цаашид хөгжүүлэх жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлийг сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулан ажиллаж байгаа.

- Арьс шир, ноос үслэг эдлэл боловсруулах
- Сүү сүүн бүтээгдэхүүн савлах
- Жимс жимсгэнэ, хүнсний ногоо савлах
- Ахуйн хог хаягдал боловсруулах
- Аялал жуулчлал хөгжүүлэх
- Засвар үйлчилгээ
- Модон эдлэл

**ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ЗОРИЛТ**

Хөрөнгө оруулалтын талаар 8			
№	Үндсэн чиглэл	Хүрэх түвшин	Хариуцах байгууллага
1	Нийтийн халуун ус саун байгуулна.	Нийтийн ариун цэвэр соёлжилт, сумын соёлын түвшин дээшилнэ.	ЗДТГ
2	Цэцэрлэгийн бохир цэвэр усны шугам сүлжээг байгуулна	Цэцэрлэгийн хүүхдүүдийн амьдрах боловсрох орчинг сайжруулна.	Цэцэрлэг
3	Хог хаягдлын менежментийг сайжруулна.	Орчны эрүүл ахуй, сумын соёлжилт тохижилт сайжирна	ЗДТГ
4	Эрүүл мэндийн төвийн цэвэр бохир усны шугамыг засварлана.	Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тохь тухыг хангасан байна.	ЭМТөв
5	Сумын хэсгийн төлөөлөгчийн ажиллах нөхцлийг сайжруулан бэлэн бус торгуулийн машин, замын хөдөлгөөний хяналтын драгер багажаар хангана.	Хэсгийн төлөөлөгчийн ажлын үзүүлэлт сайжирч хуулийн хэрэгжилт хангагдана.	ЗДТГ
6	Түргэн тусламжийн автомашиныг шинэчилнэ.	Анхан шатны тусламж үйлчилгээг шуурхай хүргэнэ	ЭМТөв
7	Сумын төвийн инженерийн шугам сүлжээний зураг төсвийг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлнэ.	Шинэ сумын төв төслийн эхлэл тавигдсан байна.	ЗДТГ
8	Иргэдийг орон сууцжуулах ажлыг дэмжиж хөнгөлөлттэй зээл тусламжинд хамруулах ажлыг зохион байгуулна.	Иргэдийн ая тохьтой амьдрах орчныг сайжруулах, орчин үеийн шаардлагад нийцүүлсэн байна. Санал санаачлага гаргасан иргэдэд дэмжлэг үзүүлсэн байх	ЗДТГ
1. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын талаар /6 зорилт/			
1	“ Архидалтгүй- Баян Адрагачууд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Архины хамааралтай иргэдийн тоо 20 хувиар буурсан байх	ЗДТГ, ЭМТөв
2	“ Ажил –орлоготой өрх” хөтөлбөрийг батлуулж хэрэгжүүлнэ	Өрхийн орлого нэмэгдэж байнгын ажлын байр 20 –аас доошгүй нэмэгдсэн байна.	ЗДТГ, Байгууллагууд

3	Нийгмийн халамж үйлчилгээний ил тод байдлыг хангаж иргэдийг мэргэжил мэдлэг дээшлүүлэх, эзэмшүүлэх сургалтад хамруулна	Хуулийн хэрэгжилт хангагдаж иргэдийн хөдөлмөр эрхлэлт нэмэгдэнэ. Сургалтад 20 –оос доошгүй иргэдийг хамруулна.	Халамжийн байгууллага, ЗДТГ
4	Сумын иргэдийг нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг оношлогоононд хамруулж өвчний эрт илрүүлэлтийг нэмэгдүүлнэ	Иргэдийн өвчлөл буурч, урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамрагдсан байна.	ЭМТөв
5	ЖДҮДСан, СХСангийн зээлд иргэд, байгууллагуудыг хамруулж үйл ажиллагааг дэмжин, сангийн хөрөнгийг үр дүнтэй эргэлтэд оруулна.	Иргэдийн байнгын ажлын байр 20 – оос доошгүй, түр ажлын байр 50 –аас доошгүй нэмэгдсэн байна.	ЗДТГ
1. Байгаль орчин аялал жуулчлалын талаар /7 зорилт/			
1	Түүхэн дурсгалт газруудыг тэмдэгжүүлнэ	Түүхэн дурсгалт газруудын хамгаалалт сайжирна	ЗДТГ
2	Сумын хилийн цэсийг тэмдэгжүүлнэ	Нутгийн зааг ялгааг ил тод болгоно	ЗДТГ
3	Газрыг зүй ёсны эрхээр эзэмшүүлэх ажлыг олон нийтэд сурталчлан таниулж гэрээгээр эзэмшигчийн тоог нэмэгдүүлэн газрыг эдийн засгийн эргэлтэд оруулна.	Ажил орлоготой өрхийн тоо нэмэгдэж газар эдийн засгийн эргэлтэд орсон байна. Газрыг зүй зохистой эзэмшигчийн тоо 5 –аар нэмэгдсэн байна.	ЗДТГ
4	Ногоон байгууламжийг нэмэгдүүлж, эзэнжүүлнэ	Сумын төвийн ногоон байгууламж 20 хувиар нэмэгдэж ногоон байгууламжуудыг эзэнжүүлэн хамгаалалтад авна.	ЗДТГ
5	Монгол хатдын өргөө цогцолборыг бүрэн ашиглалтад оруулж улсын комисст хүлээлгэн өгнө	МХӨргөө нь аялал жуулчлалын салбарын гол түшиг болж хөгжинө	МХӨЦАӨЗ
6	“ Монгол хатад” яруу найргийн наадам зохион байгуулна	Аялагч жуулчдын тоог нэмэгдүүлнэ	МХӨЦАӨЗ
7	Хүслийн модыг тохижуулна.	Аялагч жуулчдыг татах, тэдний хүсэл сонирхлыг нэмэгдүүлнэ	ЗДТГ
1. Хөдөө аж ахуйн талаар /3 зорилт/			
1	Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлнэ	Уст цэгийн тоо 3 –аар нэмэгдэнэ	ЗДТГ, МЭҮТ
2	Өндөр ашиг шимт малын бүсийн үзэсгэлэн худалдааг суманд зохион	Малын үүлдэр угсаа чанар дээшилнэ	ЗДТГ, МЭҮТ

	байгуулна		
3	Төмс хүнсний ногоо эрхлэгчдийг дэмжиж зоорь хүлэмжийн аж ахуйг хөгжүүлнэ	Өрхийн орлого нэмэгдэн хүнсний нөөц сайжирч хүлэмж,зоорийн тоо 10 – аар нэмэгдэнэ	ЗДТГ, МЭҮТ
1. Төрийн захиргааны талаар /2 зорилт/			
1	Иргэдэд “нээлттэй утас” тогтмол ажиллуулна	Иргэдээс өргөдөл гомдол хүлээн авч барагдуулах ажлыг сажруулна	ЗДТГ, ИТХ
2	Иргэдэд төр засгийн мэдээлэл хүргэх ажлыг шуурхай ил тод олгох зорилгоор телевиз ажиллуулна	Иргэдэд мэдээлэл шийдвэрүүд шуурхай хүрч, иргэд төрийн байгууллагуудын уялдаа сайжирна	ЗДТГ, ИТХ
1. Спорт, соёлын талаар /1 зорилт/			
1	Оюунлаг – спортлог Адрагачууд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ	Иргэдийн мэдлэг оюуныг хөгжүүлэх тусгай хөтөлбөр боловсруулж батлуулан хэрэгжүүлнэ.	ЗДТГ, Байгууллагууд